



## БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 07 сарын 31 өдөр

Дугаар А/529

Булган сум

“Айраг фестиваль 2025” эвент арга хэмжээг  
зохион байгуулахад хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 60.1.21 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Аялал жуулчлалын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.1, 23.1.9 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 65.1.3, 65.1.4 дэх заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны IV хуралдааны аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны “Булганы сэргэлт хөтөлбөрийг батлах тухай” IV/25 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2025 оны “Хөтөлбөр, төлөвлөгөө, арга хэмжээний зардал батлах тухай” А/360 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. ЮНЕСКО-гийн Хүн төрөлхтний соёлын биет бус өвд Монгол Улсаа төлөөлөн бүртгэгдсэн Хөхүүрийн айрагны соёлыг түгээн дэлгэрүүлэх, олон нийтэд сурталчлан таниулах, адуу маллагаа, уламжлалт ахуй ёс заншлыг хадгалан хамгаалах зорилгоор “Айраг фестиваль 2025” эвент арга хэмжээг 2025 оны 08 дугаар сарын 08-09-ний өдрүүдэд зохион байгуулсугай.

2. Зохион байгуулалтад шаардагдах зардлыг хавсралтаар баталж Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээний “Аялал жуулчлалын эвент арга хэмжээг зохион байгуулах” төсөл арга хэмжээний зардлаас 38,032,000 (гучин найман сая гучин хоёр мянга) төгрөгийг зарцуулахыг сангийн нягтлан бодогч (Э.Эрдэнэжаргал), Аймгийн Засаг даргын тамгын газрын нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрсөн Булган аймаг, “Эрдэнэт үйлдвэр” Төрийн өмчийн үйлдвэрийн газрын 2025 онд хамтран ажиллах төлөвлөгөөний зардлаас 100,000,000 (нэг зуун сая), Аймгийн Засаг даргын Уул уурхайн компаниудтай байгуулсан Нийгмийн хариуцлагын гэрээний санхүүжилтээс Аймгийн Засаг даргын Тамгын газрын нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрсөн хөрөнгөөс 67,668,000 (жаран долоон сая зургаан зуун жаран найман мянга), аймгийн Засаг даргын хөтөлбөр, төлөвлөгөө хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас 10,000,000 (арван сая) төгрөгийг зарцуулахыг Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Эрдэнэбилэг) нарт зөвшөөрсүгэй.

3. “Айраг фестиваль 2025” эвент арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулах, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (О.Ундрах)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



Сугар Ажил 2025 өдөр бүр Doc/2025/Захирамж

6325010733

Аймгийн Засаг даргын 20.15 оны  
07 дугаар сарын 31-ны/ний өдрийн  
А/529 дугаар захирамжийн хавсралт

**“АЙРАГ ФЕСТИВАЛЬ 2025” ЭВЕНТ АРГА ХЭМЖЭЭГ  
ЗОХИОН БАЙГУУЛАХАД ШААРДАГДАХ ТӨСӨВ**

д/д	Зориулалт, арга хэмжээ	Ирүүлсэн санал /мян.төг/	Хянасан төсөв /мян.төг/
1	2	3	4
1	Арга хэмжээний тэмцээн уралдааны зардал	49,659.7	35,878.5
2	Хүндэт зочид болон соёл, урлагийн арга хэмжээний зардал	106,727.9	104,128.4
3	Хэвлэл мэдээллийн зардал	31,276.0	17,555.0
4	Иргэд олон нийтийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хангахад чиглэсэн зардал	70,535.0	48,138.1
	<b>Дүн</b>	<b>258,198.6</b>	<b>215,700.0</b>